


ХИЧЭЭЛ 13

УНШИХ ЗҮЙЛ: ЛУК 2:21-38; ДАГАЛДАГЧДЫН ҮЙЛС, Х. 50-58.

Бурханд Өргөсөн нь

Та нар хүүхдийг сүмд өргөж байхыг үзсэн үү? Та нарыг Бурханд өргөсөн үү? Есүсийг аав ээж нь сүмд аваачин, Бурханд өргөжээ.



С айн байна уу, анд минь. Намайг Марь гэдэг. Харин энэ бол миний бяцхан хүү. Нэрийг нь Есүс гэдэг юм.

Тэнгэр элч бидэнд хүүгээ Есүс гэж нэрлэ гэж хэлсэн тул Иосеф бид хоёр ингэж нэрлэсэн юм. Тэр бол онцгой хүүхэд. Бурханы хүү. Бас миний бяцхан

хүү. Би түүндээ маш их хайртай. Тэр маань хөөрхөн бас үнэлж баршгүй эрдэнэ.

Нэгэн өдөр юу болсон тухай би одоо та нарт ярьж өгье. Бид Бурханд хүүгээ даатгахаар Иерусалим хотын сүм рүү очсон юм. Манай нутагт айл бүр ууган хүүгээ сүм дээр аваачиж, тусгай ёслол гүйцэтгэж, дараа нь шатаалт өргөл өргөдөг уламжлалтай. Бид өргөл болгон шатаах хоёр тагтаа авч явлаа. Харин өнөөдөр бол та нар мөнгөө хандивладаг шүү дээ.

Сүмийн зэрэгтэн бидний өргөлийг хүлээн авч байтал Симон



Цээжлэх Ишлэл:
“Хүүхдүүд бол Их Эзэний өгсөн бэлэг”
ДУУЛАЛ 127:3.

Тол Санаа:
Бурхан хүнд бүрт бэлгээ хүртээдэг.

гэдэг настай хүн бидэнд дээр хүрч ирлээ. Тэр дөхөж ирээд, Есүсийг харж болох уу гэж асуусан юм. Би зөвшөөрч, хүүгээ түүнд өгөв. Симон өвгөн Есүсийг гартаа тэвэрлээ. Дараа нь тэрээр хүн төрөлхтний Аврагчийг харах боломж олгож, бяцхан Есүсийг үзүүлсэн Бурханд талархаж эхэлсэн юм. "Мөнхийн Эзэн минь, та амласан ёсоороо надад нүд анихаас минь өмнө, Израйль болон харийн үндэстнүүдийн гэрэл, хүн төрөлхтнийг аврах бяцхан хүүг үзүүллээ." Симон Иосеф бид хоёрыг хүртэл ерөөсөн юм. Бид маш их гайхаж байлаа. Есүс бол онцгой хүү гэдгийг бид мэдэж байсан ч бүх зүйлийн учрыг хараахан ойлгоогүй байсан юм.

Дараа нь Анна гэдэг настай эмэгтэй бидэнд дээр хүрч ирсэн юм. Хүүг тань харж болох уу гэж асуулаа. Мэдээж бид зөвшөөрсөн. Тэр миний өмнө харж байгаагүй тийм сайхнаар инээмсэглэсэн юм даа. Ингээд тэр эмэгтэй Есүсийг маань харсандаа Бурханд талархаж эхэллээ. Дараа нь тэрээр биднийг ажиглан зогссон хүмүүст хандан Есүс бол онцгой хүүхэд гэж тунхаглав. Хүү маань хүн бүрийг аврах болно гэдгийг тэрээр хүмүүст хэлж байсан юм.

Хүүг маань амласан Аврагч мөн гэж тэрээр хэлэв. Улмаар маш олон зүйл болж өнгөрлөө. Тэр болгоныг бодож учрыг нь олох гээд бид чадаагүй. Гэхдээ бид их баяртай байсан. Бүр хожим нь би Симон өвгөн болон Анна нарын ярьсан зүйлийн талаар дахин бодсоор байсан.

Үнэхээр гайхамшигтай өдөр болж өнгөрсөн юм. Симон Анна хоёр хүүд маань байгаа онцгой зүйлийг олж харжээ. Тэр хоёр хоёулаа хүүг маань бүх хүмүүсийг аварна, Есүс бол дэлхий ертөнцийг аврах тэрхүү амласан Аврагч мөн гэж хэлсэн.

Иосеф бид хоёр Есүс хүү маань учраас маш их хайртай байсан. Тэр бол Бурханы бидэнд өгсөн бас хүн төрөлхтөнд өгсөн бэлэг гэдгийг бид сайн мэддэг. Чи ч бас Бурханы бэлэг учраас аав ээж чинь та нарт тийм хайртай байдаг юм шүү дээ. Бурханы хувьд хүүхэд бүхэн чухал.



Дасгал Ажил

ШАББАТ

Энэ долоо хоногийн туршид өдөр бүр Библийн түүхээ уншиж, цээжилсэн ишлэлийг нь хамтдаа давтаарай.

Хүүхдүүд болХүүхдүүд рүү заах.

Их ЭзэнийДээшээ заах.

өгсөн бэлэг.Юм өгч байгаа мэт гараа урагш сунгах.

Дуулал 127:3Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

НЯМ

Шаббат хичээл дээр хийсэн номын хавчуургаа хэн нэгэнтэй хуваалцаж түүнд Есүсийг Бурханд өргөсөн тусгай үйлчлэлийн талаар ярихад нь хүүхдээ урамшуулаарай. (Эсвэл та хатуу цаасан дээр цээжлэх ишлэлийг нь бичиж өгөөд, дараа нь хүүхдээрээ чимэглүүлээд, хайчлаарай.)

ДАВАА

Лук 2:21-38-г хамтдаа уншаарай. Асуух: Бяцхан Есүсийг хаана Бурханд өргөсөн бэ? (Иерусалим хотын сүм дотор) Сүм дотор Есүсийг харсандаа хэн баяртай байсан бэ? (Симон Анна хоёр) Яагаад? Симон, Анна хоёрын хэлсэн зүйлийн талаар Марь юу гэж бодсон бэ?

"Их Эзэн Жаал Хүү" дууг хамт дуулаад, Есүсийн төлөө Бурханд талархаарай.

МЯТГАР

Нялх хүүхдийн, хүүхдийн мөн гэр бүлийн зурагтай номуудыг үзээрэй. Иосеф, Марь хоёр Есүст хичнээн хайртай байсан мөн өнөөдөр ч гэсэн аав ээжүүд хүүхдэдээ хичнээн хайртай байдаг тухай ярьж өгөөрэй. Залбирахаасаа өмнө хамтдаа "Есүс надад хайртай" эсвэл "Есүс хүүхдүүдэд хайртай" гэдэг дууг дуулна уу.

ЛХАТВА



Хүүхдийнхээ нуруун дээр ямар нэг чихмэл тоглоом тавиарай. Тэгээд нуруун дээрх зүйлээ унагаалгүй өрөөн дотуураа мөлхөөрэй гэж хүүхдэдээ хэлнэ үү. Бага байхдаа хүүхэд тань яаж мөлхдөг байсан тухай хүүхдэдээ ярьж өгөөрэй. Асуух: Чи юу юу хийж сурсан бэ? Чи том болохдоо Есүсийн тухай юу юу мэддэг болсон бэ? Хүүг тань өсгөж том болгож байгаагийнх нь төлөө Есүст талархаарай.

ПҮРЭВ

Хамтдаа хүүхдийнхээ багынх нь зургийг, ивээл хүртэж буй зургийг нь үзээрэй. Тэр үед ямар сэтгэгдэл төрж байснаа ярьж өгөөрэй.

Та асуулт асуухдаа хүүхдээ толинд харуулаарай. Хэн Бурханы өгсөн онцгой бэлэг вэ? (чи) Хэлэх: Хүн бүрт зориулсан Бурханы онцгой бэлэг хэн бэ? (Есүс)

БААСАН

Библийн түүхийг гэрийнхэнтэйгээ хамт жүжиглээрэй. Бяцхан Есүсийг хүүхэлдэйгээр төлөөлүүлж, түүнийг алчууранд өлгийдөөрэй.

Хүүхдээ тэврээд түүнд чи бол Бурханы надад өгсөн онцгой бэлэг гэдгийг түүнд дахин хэлээрэй. Би чамдаа хайртай гэж хүүхдэдээ хэлээд Есүс мэндэлсэн тухай дууг хамтдаа дуулаад, хүү болон Есүсийн төлөө Бурханд таларх. Есүс бол хүн төрөлхтөнд өгсөн Бурханы хамгийн онцгой бэлэг.

